

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/12 дугаар тушаалын 1-р хавсралт

ОРХОН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЖИЛЧДЫН АЖЛЫН ҮР ДҮН, УР ЧАДВАРЫГ ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Ус цаг уур орчны шинжилгээний төвийн албан хаагчдын ажлын үр дүн, ур чадварыг үнэлж дүгнэхэд энэхүү журмыг баримтална.
- 1.2 Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн ажилчдын үр дүн, ур чадварыг хөдөлмөрийн гэрээний биелэлт, шинжилгээний ажлын дүн, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал харилцаа хандлага, ёс зүй, бусад ажлын үнэлгээ гэсэн мэдээллийг үндэслэж дүгнэнэ.

	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ/ оноо/
1	Хөдөлмөрийн гэрээний биелэлт, шинжилгээний ажлын дүн	70
2	Харилцаа хандлага, ёс зүй	15
3	Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байдал	10
4	Бусад ажил	5
	Нийт оноо	100

- 1.3 Ажил дүгнэхдээ шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж дүнг нэгтгэн төвийн даргын зөвлөлд танилцуулна.
- 1.4 Тухайн ажилтныг шууд удирдах хэлтсийн дарга хагас, бүтэн жилээр дүгнэж дор дурдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Хэлтсийн даргын өгсөн үнэлгээтэй санал нийлээгүй тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг төвийн даргад бичгээр гаргаж болно.
- 1.5 Ажлын үр дүн нь доорх байдлаар дүгнэгдсэн ажилтанд улиралын урамшуулалыг үндсэн цалингийн 10-40 хувиар бодож олгоно.
- 96-100 оноо авсан бол "А+" буюу "Маш сайн" 40 хувь
 - 91-95 хүртэл оноо авсан бол "А" буюу "Сайн" 30 хувь
 - 86-90 хүртэл оноо авсан бол "В+" буюу "Хангалттай сайн" 20 хувь
 - 80-85 хүртэл оноо авсан бол "В" буюу "Хангалттай" 10 хувь
- Тайлбар: 70 онооны үнэлгээг энэхүү журмын 2-р хавсралтаар, 15 онооны үнэлгээг байгууллагын ёс зүйн зөвлөлийн дүгнэлтээр, 10 онооны үнэлгээг хүний нөөцийн ажилтаны бүртгэлээр, 5 онооны үнэлгээг байгууллагаас зохион байгуулсан ажлын идэвх, бүртгэлээр тус тус үнэлж дүгнэнэ.
- 1.6 Эрхэлж буй албан тушаалын ажилдаа сайн туршлагаар ажиллаж амжилтанд хүрсэн, цаг агаарын аюултай үзэгдэл болон орчны бохирдол, өөрчлөлтийг үнэн зөв мэдээлсэн буюу мэдээлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн, олон жил ажиллаж ийм чадварыг эзэмшсэн ажилтанд ур чадварын нэмэгдлийг улирлаар дүгнэж сар тутам олгоно. Ингэхдээ ажилтаны хөдөлмөрийн гэрээний биелэлт, ажилласан жил, шинжилгээний ажлын дүнг улсын дундажтай харьцуулан дүгнэж доорх хүрэх түвшинг хангасан бол харгалзах хувиар олгоно.


А. Ур чадварын нэмэгдэл олгох хүрэх түвшин

Албан тушаал	Улсын дундаж ба суурь түвшин	Хүрэх түвшин ба хувь			
		25	20	15	10
ЦУТМҮХ-ийн дарга бөгөөд ХААЦУ-ын технологич инженер	99.3	99.6-100	99.1-99.5	98.6-99.0	98.0-98.5
Цаг уурын ерөнхий технологич инженер бөгөөд БХЗТинженер	99.1	99.6-100	99.1-99.5	98.6-99.0	98.0-98.5
Синоптикийн ерөнхий технологич инженер	97.4	99.1-99.6	98.6-99.0	98.1-98.5	97.4-98.0
Эрдэнэт-Овоо өртөөний дарга	99.3	99.6-100	99.1-99.5	98.6-99.0	98.0-98.5
Өртөө, харуулын техникч	99.1			99.6-100	99.0-99.5
ЗТХ-ийн дарга бөгөөд МДС-ийн технологич инженер	98.6	95.1-100	90.1-95.0	85.1-90.0	80.1-85.0
Ахлах нягтлан бодогч	97.9	95.1-100	90.1-95.0	85.1-90.0	80.1-85.0
Хүний нөөцийн ажилтан бөгөөд нярав	99.5	95.1-100	90.1-95.0	85.1-90.0	80.1-85.0
Архив, албан хэргийн ажилтан	98.5	95.1-100	90.1-95.0	85.1-90.0	80.1-85.0
БОШЛ-ын ерөнхий технологич инженер	99.4	99.7-100	99.4-99.6	99.0-99.3	98.5-98.9
БОШЛ-ын технологич инженер, техникч		99.7-100	99.4-99.6	99.0-99.3	98.5-98.9
Экспидецийн инженер, сүлжээ, аюулгүй байдал хариуцсан ажилтан	99.8	99.8-100	99.5-99.7	99.2-99.4	99.1-99.3
Техникч-жолооч	98.0	95.1-100	90.1-95.0	85.1-90.0	80.1-85.0
Үйлчлэгч	98.0	95.1-100	90.1-95.0	85.1-90.0	80.1-85.0

Б. Ур чадварын нэмэгдэл олгох нэмэлт нөхцөл

д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин / Хувь /
1	Цаг уурын салбарт 26 ба түүнээс дээш жил ажилласан бол	15
2	Цаг уурын салбарт 15-25 жил ажилласан бол	10
3	Ажил хавсран гүйцэтгэдэг бол	10
4	Шинжилгээний ажлын дүн улсад 1-р байранд орсон бол	10

- 1.7 Захиргааны чөлөөтэй байсан буюу шинээр ажилд орсон ажилтанд үр дүн, ур чадварын нэмэгдлийг нэг улирлаас доошгүй хугацаагаар ажилласан тохиолдолд олгоно. Хагас, бүтэн жилээр олгох үр дүнгийн урамшууллыг ажилласан хугацаанд нь харгалзан олгоно.
- 1.8 Ажлын үр дүн, хөдөлмөрийн гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн урамшуулах, эсхүл хариуцлага хүлээлгэх тодорхой саналаа төвийн даргын зөвлөлд танилцуулна.
- 1.9 Ажилтан хугацаатай тайлан, мэдээ хоцроосон, тасалсанэсвэл сахилгын шийтгэл авсан бол үр дүнгийн ба ур чадварын нэмэгдэл олгохгүй.
- 1.10 Үнэлгээтэй танилцсан албан хаагчид тус тусын гарын үсгийг зурж, эрх бүхий этгээд тэмдэг дарж албажуулна.



Албан тушаал	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин
Захиргаа төлөвлөлтийн хэлтсийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт		
Хэлтсийн дарга бөгөөд ИС-ийн технологич инженер	Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг чанартай хийж хугацаанд нь хагас, бүтэн жилээр биелэлтийг гаргаж хүргүүлсэн байх
	Байгууллагын дотоод журмыг мөрдлөг болгож төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг сахиулах, эрх зүйн зөрчилгүй ажиллах	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг дагаж, эрх зүйн зөрчилгүй ажилласан байх
	Байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалт хийх	Дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу хэлтсүүдэд хийж төвийн даргад танилцуулсан
	Хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх	Хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин зөрчилгүй ажилласан байх
	Байгууллагын санхүү, хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Санхүү, хүний нөөцийн бодлогыг тодорхойлж сул ажлын байрны нээлттэй зар тавьж сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу хийж хүний нөөцийг бүрдүүлсэн байна
	Мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг хугацаанд нь зохих журмын дагуу хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтныг бүрэн хамруулсан байна.ХАСХОМ тайлангийн үнэн бодит байдлыг хангаж хугацаанд нь хүргүүлэх	Мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг хугацаанд нь зохих журмын дагуу хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтныг бүрэн хамруулсан байна.
	Аж ахуй нэгж байгууллагатай ажлын гэрээ байгуулж, дүгнэх	Аж ахуй нэгж байгууллагатай ажлын гэрээ байгуулж, дүгнэсэн байна
	Мэдээллийн сангийн нэгдсэн тоо бүртгэл хөтөлж жил, хагас жилээр тайлан гаргах	Мэдээллийн сангийн нэгдсэн тоо бүртгэл хөтөлж жил, хагас жилээр тайлан гаргаж цаг хугацаанд нь хүргүүлсэн байна
	Нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг жил бүр батлуулан мөрдөх	Мэдээллийн сангийн ажлын болон нөхөн бүрдүүлэх төлөвлөгөөг гарган батлуулж мөрдсөн байна
	Шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргаж төр захиргаа, ААНБ-уудад үйлчлэх	Мэдээллийн санд байгаа мэдээллээр ААНБ болон иргэдэд шуурхай үйлчилж тэмдэглэл хөтөлсөн байна
	Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрт болон гэрээт ажлын гүйцэтгэл, нэмэлт судалгаа шинжилгээний ажилд мэдээ, мэдээллээр төр, засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд үйлчлэхэд хяналт тавих,	Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрт болон гэрээт ажлын гүйцэтгэл, нэмэлт судалгаа шинжилгээний ажилд мэдээ, мэдээллээр төр, засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд үйлчлэхэд хяналт тавин ажилласан байна
Ахлах нягтлан бодогч	Улирал, жилийн тайлан тэнцэл, төсвийн төслийг хугацаанд нь үнэн зөв гаргасан байх	Улирал, жилийн тайлан тэнцэл, төсвийн төслийг хугацаанд нь үнэн зөв гаргасан байх
	Анхан шатны бүртгэлийн хөтлөлт, баримтын боловсруулалтыг тухай бүрт нь хийж, данс бүртгэлд тусгасан байх	Анхан шатны бүртгэлийн хөтлөлт, баримтын боловсруулалтыг тухай бүрт нь хийж, данс бүртгэлд тусгасан байна
	Өр, авлагын барагдуулалтын байдал	Өр, авлагагүй ажилласан байна
	Хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж, батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байх	Хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж, батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байна

БОШЛ-ын ерөнхий технологич инженер бөгөөд чанарын менежер	Хөтөлбөрт ажлын биелэлт	Хөтөлбөрт ажлууд тасраагүй хугацаандаа хийгдсэн байна
	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж дүнг төвд явуулах	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж хангалттай үнэлэгдсэн байна
	Бодис урвалж найруулж, жишиг тахирмаг байгуулах	Бодис урвалж найруулж, жишиг тахирмаг байгуулах ажлыг чанартай хийсэн байх
	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайлан	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайланг хугацаанд нь чанартай хийсэн байна
	Гэрээт байгууллагын шинжилгээ хяналт	Гэрээт байгууллагын шинжилгээ хяналтыг хийж үйлчилсэн байна
Хүний нөөцийн ажилтан бөгөөд нярав	Байгууллагын албан хаагчдын дэлгэрэнгүй судалгаа, мэдээллийг ХНУМТ системд тухай бүр баяжуулан шинэчлэх	Байгууллагын албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг хийж, мэдээллийг ХНУМТ системд тухай бүр баяжуулан шинэчлэсэн байна
	Байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн баяжилт хийх, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргаж Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх	Албан хаагчдын хувийн хэргийг тухай бүрт нь нээж, баяжилтыг зохих журмын дагуу хийсэн байна. Төрийн албаны салбар зөвлөлд тайлан, мэдээг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.
	Ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэлтэй холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авч байх	Ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэлтэй холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна
	Байгууллагын салбар комиссын болон даргын зөвлөлийн хурал, шуурхай зөвлөгөөн, цаг үеийн шинжтэй ажлыг зохион байгуулах	Байгууллагын салбар комиссын болон даргын зөвлөлийн хурал, шуурхай зөвлөгөөн, цаг үеийн шинжтэй ажлыг зохион байгуулж, албан хаагчдын ирц, оролцоог бүртгэж, хурлын тэмдэглэл хөтөлсөн байна.
	Ажилтан нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаж, үр дүнд хүрсэн байх	Ажилтан нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаж, үр дүнд хүрсэн байна
	Өмч хөрөнгийг бүртгэл, хадгалалт хамгаалалтын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж тооллого хийн, бүртгэл хөтөлж, анхан шатны баримтыг үндэслэн НББ-ийн олон улсын стандартын дагуу бараа материалын тайлан гаргах	Өмч хөрөнгийн тооллого чанартай хийж, бүртгэл хөтөлж, өмч хамгаалах комиссыг хуралдуулсан байна. НББ-ийн олон улсын стандартын дагуу бараа материалын тайланг цаг хугацаанд нь чанартай хийсэн байна
	Шинээр нэмэгдэж байгаа хөрөнгө болон материалыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэлд тусгах	Шинээр нэмэгдсэн хөрөнгийг өмч хамгаалах комисс хуралдуулж акт үйлдэн, хөрөнгийг зургаар баталгаажуулан хүлээн авч бүртгэлд тусгасан байна
	Бараа материалыг захиалгын дагуу олгох, зарцуулалтыг хянах, АШБ-ыг үндэслэн бүртгэлд тусгах	Бараа материалыг захиалгын дагуу ЗТХ-ийн даргын зөвшөөрлөөр олгож бүртгэлд тусгасан байна
	Үндсэн хөрөнгө, бараа материал, хөрөнгийг зөв зохистой хадгалах, агуулахыг эмх цэгцтэй байлгах	Үндсэн хөрөнгө, бараа материалыг зөв зохистой хадгалж, агуулахыг эмх цэгцтэй байлгаж цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэсэн байна.
	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Бичиг хэргийг эмх цэгцтэй хөтөлж, архивын бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалж, хамгаалах
Ирсэн бичгүүдийг зөв хаягласан, бүрдэл бүрэн эсэхийг шалгаж хүлээн авч И-оффис системд бүртгэн, удирдлагад танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгөн хариунд хяналт тавих		И-оффис системийн ажиллагаа, бүртгэл хугацаандаа хийгдсэн. Гаднаас ирсэн хариутай бичгийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.

	<p>Байгууллагаас гарч буй албан бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд хэвлэж гарын үсэг, тамга тэмдэгийн бүрэн эсэхийг шалган дугаар өгч, бүртгэл үйлдэн цаг хугацаанд нь шуурхай хүргүүлж байх</p>	<p>Албан бичгийг стандартын дагуу хэвлэж, бүртгэл хөтлөн цаг хугацаанд нь хүргүүлсэн байна</p>
	<p>Байгууллагын тамга, албан бичгийн нүүр, баталгааны тэмдэг, албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудсыг /тушаал, албан бичиг/ стандартын дагуу хийлгэж, бүртгэлжүүлэн хадгалалт хамгаалалтыг хариуцах</p>	<p>Байгууллагын тамга, албан бичгийн нүүр, баталгааны тэмдэг, албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудсыг стандартын дагуу хийлгэж, бүртгэлжүүлсэн байна</p>
	<p>Байгууллагын архивт хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, нэгжүүдээс нөхөн бүрдүүлэлт хийх, баримтын нягтлан шалгаж ангилан төрөлжүүлэх, БНШК-ийн хурал хийх</p>	<p>Байгууллагын архивт хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, нэгжүүдээс нөхөн бүрдүүлэлт хийсэн байна. Баримтыг нягтлан шалгаж ангилан төрөлжүүлж, БНШК-ийн хурал 1-2 удаа хийж тэмдэглэл хөтөлсөн байна.</p>
	<p>Баримтын хадгалалт, хамгаалалт, гал усны болзошгүй аюулаас сэргийлэн, гэмтэлтэй баримтыг сэргээн засварлах</p>	<p>Баримтын хадгалалт, хамгаалалт, гал усны болзошгүй аюулаас сэргийлэн, гэмтэлтэй баримтыг сэргээн засварласан байна</p>
	<p>Мэдээллийн дэд санд байхгүй мэдээллийг шаардлагатай бол харъяалах салбар хэлтсээс сүлжээгээр болон зөөврийн хадгалуураар акт үйлдэн хүлээн авах, зохих шатны шалгалт, хяналтыг хийх</p>	<p>Мэдээллийн дэд санд байхгүй мэдээллийг шаардлагатай бол харъяалах салбар хэлтсээс сүлжээгээр болон зөөврийн хадгалуураар акт үйлдэн хүлээн авч, зохих шатны шалгалт, хяналтыг хийсэн байна</p>
<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">ЦАЗН ажиллагааны инженер бөгөөд сүлжээ, аюулгүй ажиллагааны ажилтан</p>	<p>Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны бэлэн байдал хангаж, хээр байрлах газар орныг сонгох, галт хэрэгсэл, пуужинг харвалтанд бэлтгэх, шалгах, харвалтыг удирдах, ажлын явцыг хянах</p>	<p>Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд оролцсон байна</p>
	<p>Пуужин, харвах төхөөрөмжийн засвар, үзлэг үйлчилгээг тогтмол хийж, хадгалалт тээвэрлэлтийн журмыг чанд сахин, байнгын бэлэн байдлыг хангах</p>	<p>Пуужин, харвах төхөөрөмжийн засвар, үзлэг үйлчилгээг тогтмол хийж, хадгалалт тээвэрлэлтийн журмыг чанд сахин, байнгын бэлэн байдлыг ханган ажилласан байна</p>
	<p>ЦАЗН-үйл ажиллагааны үр дүнг тооцох, үйл ажиллагааны талаарх акт, тайлан, мэдээ мэдээллийг цаг тухайд нь хийж, дээд газарт тайлагнах</p>	<p>ЦАЗН-үйл ажиллагааны үр дүнг тооцон, үйл ажиллагааны талаарх акт, тайлан, мэдээ мэдээллийг цаг тухайд чанартай хийж тайлан, мэдээг хүргүүлсэн байна</p>
	<p>Байгууллагын бүх компьютерүүдийн бэлэн байдлыг хангаж, интернет орчинд сүлжээг вирусээс хамгаалах, засвар үйлчилгээг тогтмол хийх</p>	<p>Байгууллагын бүх компьютерүүдийн бэлэн байдлыг хангаж вирусын программ суулгасан байна. Засвар үйлчилгээг тогтмол хийсэн байна</p>
	<p>Гадаад, дотоод мэдээ солилцоо, мэдээлэл үйлчилгээний ажлын явцад хяналт тавьж, гарсан саатал, зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авч байх</p>	<p>Сүлжээ ашиглалт, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажилласан байна. Гарсан саатал зөрчлийг шуурхай арга хэмжээ авч ажилласан байна</p>
	<p>Газардуулга, аянга зайлуулагч, зай хураагуурууд (UPS тэжээлийн блок, автомат станц, компьютер) цахилгаан тэжээлийн хэвийн байдлыг тогтмол хянаж, шалгаж байх</p>	<p>Газардуулга, аянга зайлуулагч, зай хураагуурууд (UPS тэжээлийн блок, автомат станц, компьютер) цахилгаан тэжээлийн хэвийн байдлыг тогтмол хянаж, шалгасан байна</p>
	<p>Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн улирлын дүн</p>	<p>УСУАҮХ-ээс ирүүлсэн улирлын дүнг улсын дунджаас буулгахгүй ахиулсан байна</p>

	Хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтнуудын ажлын байранд хяналт тавих ХАБЭА-н дотоод хяналт шалгалтыг хийх, бүртгэл хөтлөх, илэрсэн зөрчлийг арилгуулах	Байгууллагын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж зөрчилгүй ажилласан байна. ХАБЭА-н зааварчилгааг албан хаагчдад өгч бүртгэл хөтөлсөн байна
	Ажилтнууд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан эсэхэд хяналт тавих, шаардлагатай судалгаа, дүгнэлт, зөвлөмжийг өгөх	Ажилтнууд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан эсэхэд хяналт тавих, шаардлагатай судалгаа, дүгнэлт, зөвлөмжийг өгсөн байна
БОШЛ-ын агаар, хөрсний инженер	Хөтөлбөрт ажлын биелэлт	Хөтөлбөрт ажлууд тасраагүй хугацаандаа хийгдсэн байна
	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж дүнг төвд явуулах	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж хангалттай үнэлэгдсэн байна
	БОШЛ-ын мэдээгээр үйлчилсэн байдал	БОШЛ-ын мэдээгээр сайт болон аж ахуйн нэгж, иргэдэд үйлчилсэн байна
	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайлан	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайланг чанартай хийж хугацаанд нь хүргүүлсэн байна
БОШЛ-ын ус, хөрсний инженер	Хөтөлбөрт ажлын биелэлт	Хөтөлбөрт ажлууд тасраагүй хугацаандаа хийгдсэн байна
	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж дүнг төвд явуулах	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж хангалттай үнэлэгдсэн байна
	БОШЛ-ын мэдээгээр үйлчилсэн байдал	БОШЛ-ын мэдээгээр сайт болон аж ахуйн нэгж, иргэдэд үйлчилсэн байна
	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайлан	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайланг чанартай хийж хугацаанд нь хүргүүлсэн байна
БОШЛ-ын техникч-лаборант	Хөтөлбөрт ажлын биелэлт	Хөтөлбөрт ажлууд тасраагүй хугацаандаа хийгдсэн байна
	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж дүнг төвд явуулах	Хяналтын болон сорилын сорьцонд шинжилгээ хийж хангалттай үнэлэгдсэн байна
	БОШЛ-ын мэдээгээр үйлчилсэн байдал	БОШЛ-ын мэдээгээр сайт болон аж ахуйн нэгж, иргэдэд үйлчилсэн байна
	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайлан	Сарын тайлан БОХЗТЛ-т явуулсан байдал, үйл ажиллагааны тайланг чанартай хийж хугацаанд нь хүргүүлсэн байна
Техникч-жолооч	Өөрийн хариуцаж байгаа машин техникийг ариг гамтай эдэлж, техникийн үйлчилгээг тогтмол хийж байх	Өөрийн хариуцаж байгаа машин техникийг ариг гамтай эдэлж, техникийн үйлчилгээг тогтмол хийсэн байна
	Машин, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, бэлэн байдалд байлгах.	Машин, техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна
	Шатахуун, тослох материалыг нормын дагуу хэмнэлттэй зарцуулж, тооцоог санхүүтэй тогтоосон хугацаанд хийж, замын хуудсыг зохих журмын дагуу хөтөлж байх.	Шатахуун, тослох материалыг нормын дагуу хэмнэлттэй зарцуулж, тооцоог санхүүтэй тогтоосон хугацаанд хийж, замын хуудсыг зохих журмын дагуу хөтөлж гаргасан байна
	Осол гаргаагүй байх	Осол гаргаагүй байх
Үйлчлэгч	Ажлын байрны эмх цэгц нь үлгэр жишээ байж, ариун цэврийн шаардлага хангасан байх.	Байгууллагын дотор, гадна цэвэрлэгээг чанартай сайн хийсэн байна
	Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	Ажлын чиглэлээр доголдол гаргаагүй байна. Ногоон байгууламж арчлах, услах ажлыг хийсэн байна
	Байгууллагын доторхи эд хогшлыг байнга цэвэр үзэмжтэй байлгаж, бүрэн бүтэн байдлыг хангах	Байгууллагын доторхи эд хогшлыг байнга цэвэр үзэмжтэй байлгаж, бүрэн бүтэн байдлыг хангасан байна